

Монгол Улсын Ерөнхий Прокурор,  
Хууль зүй, дотоод хэргийн сайдын  
2017 оны хамтарсан тушаалын  
... дугаар хавсралт

## **Эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл, журам**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл болон түүнийг хэрэгжүүлэх журмыг тогтооход оршино.

1.2. Эрх хязгаарлах арга хэмжээ нь зөрчлийг шуурхай шалгах, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах, энэхүү ажиллагааны явцад хүн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах буюу зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хэвийн нөхцлийг хангах зорилготой.

1.3. Эрх хязгаарлах арга хэмжээг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу авна.

### **Хоёр. Хүнийг саатуулах**

2.1. Дараах байгууллагын эрх бүхий албан тушаалтан хүнийг саатуулж болно:

- 2.1.1. тагнуулын байгууллага;
- 2.1.2. цагдаагийн байгууллага;
- 2.1.3. хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах;
- 2.1.4. гадаадын иргэний хяналтын улсын байцаагч.

2.2. Эрх бүхий албан тушаалтан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 5.2 дугаар зүйлд заасан үндэслэл, хугацаагаар зөрчлийн холбогдогчийг саатуулна.

2.3. Энэ зүйлийн 2.1 дэх хэсэгт заасан албан тушаалтанд эрх олгогдсон байдал нь ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтоор тодорхойлогдоно.

2.4. Эрх бүхий албан тушаалтан зөрчлийн холбогдогчийг саатуулахдаа түүний эрхийг хангах зорилгоор дор дурдсан ажиллагааг гүйцэтгэнэ:

2.4.1. Зөрчил шалган шийдвэрлэх хуульд заасан зөрчлийн холбогдогчийн эрх, үүргийг танилцуулах;

2.4.2. зөрчлийн холбогдогчид эрх, үүргийг танилцуулсан тухай тэмдэглэл үйлдэх;

2.4.3. зөрчил үйлдэх үедээ согтуурсан, мансуурсан, хилийн дэглэм зөрчсөн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг саатуулсан бол хаана байгаа талаар зөрчлийн холбогдогчийн гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, төрөл, садангийн хүн, өмгөөлөгчийн хэн нэгэнд эсхүл түүний мэдэгдэхийг хүссэн хүнд 8 цагийн дотор мэдэгдэж, тэмдэглэл үйлдэх;

2.4.4. өмгөөлөгчтэй холбоо бариулах, ганцаарчлан уулзах боломжоор хангах;

2.4.5. хүсэлт, гомдол гаргах, шийдвэрийн хариуг хүлээн авах боломжоор хангах;

2.4.6. эмнэлгийн тусламж авах боломжоор хангах.

### **Гурав. Гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг саатуулах, барьцаа авах**

3.1. Эрх бүхий албан тушаалтан зөрчлийн холбогдогч гадаадын иргэн,

харьяалалгүй хүнийг түр саатуулах үндэслэл үүсвэл түүний эрх үүргийг мэдэх хэлээр нь тайлбарлан өгөх, шаардлагатай бол орчуулагч, хэлмэрч авах боломжоор хангасны үндсэн дээр саатуулах арга хэмжээ авна.

3.2. Эрх бүхий албан тушаалтан гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг саатуулсан бол зөрчлийн холбогдогчийн талаар гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад 24 цагийн дотор бичгээр болон харилцаа холбооны бусад хэрэгслээр мэдэгдэж энэ талаар тэмдэглэл үйлдэнэ.

3.3. Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч нь зөрчил үйлдсэн гадаадын иргэн, харьяалалгүй хүний хувийн байдлыг тогтоох, зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулж болзошгүй бол 14 хоног хүртэл хугацаагаар саатуулах хүсэлтийг бичгээр гаргаж харьяалах эрүүгийн хэргийн шүүхэд хүргүүлнэ.

3.4. Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч нь зөрчлийн холбогдогчийг саатуулсан үндэслэл арилаагүй бол зөрчлийн хэрэг, саатуулах хугацааг сунгах үндэслэл, хүсэлтээ хяналт тавьж буй прокурорт бичгээр мэдэгдэж саатуулах хугацааг 30 хүртэл хоногоор сунгуулах хүсэлтийг хугацаа дуусахаас 2 хоногийн өмнө эрүүгийн хэргийн шүүхэд хүргүүлж шийдвэрлүүлнэ.

3.5. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн өөрөө, эсхүл түүний өмнөөс бусад хүн, хуулийн этгээд зөрчил шалгах ажиллагаанд саад учруулахгүй байх үүрэг хүлээж саатуулах арга хэмжээг барьцаагаар солиулах хүсэлт гаргасан бол гадаадын иргэний хяналтын улсын байцаагч хүсэлтийг өөрийн саналын хамт харьяалах эрүүгийн хэргийн шүүхэд нэн даруй хүргүүлнэ.

3.4. Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч нь энэ зүйлийн 3.3, 3.4, 3.5 дахь хэсэгт заасан эрүүгийн хэргийн шүүхээс гарсан шийдвэрийн хуулбарыг прокурорт нэн даруй хүргүүлэх үүрэгтэй.

### **Дөрөв. Хүнийг саатуулах хугацааг сунгах**

4.1. Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба тушаалтан Зөрчлийн тухай хуулийн дараах зүйл, хэсэгт заасан зөрчлийн холбогдогч оргон зайлах, эсхүл дахин зөрчил үйлдэж болзошгүй тохиолдолд түр саатуулах хугацааг сунгах саналаа<sup>1</sup> хяналт тавьж байгаа прокурорт танилцуулна.

- 4.3.1. 5.1 дүгээр зүйлийн 3 дах хэсэг;
- 4.3.2. 5.2 дугаар зүйл;
- 4.3.3. 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг;
- 4.3.4. 5.5 дугаар зүйл;
- 4.3.5. 5.7 дугаар зүйл;
- 4.3.6. 5.8 дугаар зүйлийн 6 дах хэсэг;
- 4.3.7. 8.6 дугаар зүйл;
- 4.3.8. 8.7 дугаар зүйл;
- 4.3.9. 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг;
- 4.3.10. 15.4 дүгээр зүйл.

4.2. Хяналт тавьж байгаа прокурор саналыг үндэслэлтэй гэж үзвэл харьяалах шүүхэд 48 хүртэлх цагаар сунгуулах тухай хүсэлт<sup>2</sup> гаргаж шийдвэрлүүлнэ.

4.3. Энэ зүйлийн 4.1, 4.2 дахь хэсэгт заасан санал, хүсэлт гаргах, шийдвэрлүүлэх хугацаа түр саатуулах үндсэн хугацаа буюу 24 цагт багтсан байна.

---

<sup>1</sup> Маягт

<sup>2</sup> Маягт

## **Тав. Саатуулсан хүнийг суллах**

5.1. Эрх бүхий албан тушаалтан хүнийг саатуулсан үндэслэл арилсан, хугацаа дууссан тохиолдолд нэн даруй суллах үүрэгтэй.

5.2. Гадаадын иргэн, харъяалалгүй хүнийг саатуулах үндэслэл арилсан бол зөрчлийн холбогдогчийг суллах саналаа харьяалан шийдвэрлэсэн шүүхэд хүргүүлж шүүхээс гарсан шийдвэрийн хуулбарыг прокурорт хүргүүлнэ.

5.3. Хүнийг саатуулсан хугацааг зөрчлийн холбогдогчийг саатуулах тухай тэмдэглэл, шүүхийн шийдвэрийг түүнд танилцуулснаас эхлэн тоолно.

### **Зургаа. Хүнийг саатуулах ажиллагаанд тавих хяналт**

6.1. Нийтлэг журам батлах тухай Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаанд дотоодын хяналтыг тавина.

6.2. Прокурор эрх бүхий албан тушаалтны хүнийг саатуулах эрх хязгаарлах арга хэмжээ авсан шийдвэрийг бүртгэж, Зөрчил шалган шийдвэрлэх хуулийн 5.2 дугаар зүйлд заасан хугацаанд хяналт тавина.

6.3. Эрх бүхий албан тушаалтны зөрчлийн холбогдогчийг саатуулсан, сулласан нь үндэслэлгүй гэж үзвэл хүчингүй болгох тухай прокурорын тогтоол үйлдэж, эрх бүхий албан тушаалтан, зөрчлийн холбогдогчид мэдэгдэнэ.

6.4. Саатуулах арга хэмжээний талаарх гомдол, хүсэлтийг зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хянаж шийдвэрлэх.

6.5. Прокурор нь хяналт шалгалт хийх явцад болон зөрчлийн оролцогчийн гомдол, хүсэлтээр хэргийг хянах явцад үндэслэлгүйгээр саатуулагдсан нь тогтоогдвол зөрчлийн холбогдогчийг даруй суллах үүрэгтэй.

### **Долоо. Үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох**

7.1. Эрх бүхий албан тушаалтан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 5.3 дугаар зүйлд заасан үндэслэл тогтоогдсон бол үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох саналыг зөрчлийн хэрэг нээснээс хойш 24 цагийн дотор прокурорт хүргүүлнэ.

7.2. Үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох саналд зөрчил үйлдсэн огноо, эрх бүхий албан тушаалтны нэр, албан тушаал, зөрчлийн холбогдогчийн овог, нэр, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, зөрчлийн утга, ямар ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох, үндэслэл, хуулийн зүйл заалт зэргийг дэлгэрэнгүй бичнэ.

7.3. Прокурор эрх бүхий албан тушаалтны саналыг үндэслэлтэй гэж үзвэл үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох тухай, үндэслэлгүй бол хүлээн авахаас татгалзах тухай прокурорын тогтоол гаргана.

7.4. Прокурор нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох тухай санал болон хойшлуулшгүй тохиолдолд гаргасан шийдвэртэй танилцаад үйл ажиллагаа,

ашиглалтыг түр зогсоож буй газарт очиж санал, шийдвэрт дурдсан үндэслэл байгаа эсэхийг биечлэн үзэж танилцах, зөрчлийн холбогдогчтой уулзаж болно.

7.5. Эрх бүхий албан тушаалтан прокурорын тогтоолыг зөрчлийн холбогдогчид танилцуулснаар зөрчлийн холбогдогч үйл ажиллагаа, ашиглалтыг зогсоох үүрэгтэй.

7.6. Эрх бүхий албан тушаалтан нь ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг бүхэлд нь, хэсэгчлэн, эсхүл барилга байгууламж, машин, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалтыг түр зогсоосон талаар хэвлэл, мэдээлэлийн хэрэгслийг ашиглан олон нийтэд мэдээлж болно.

7.7. Зөрчлийн холбогдогч үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоосон шийдвэрийг биелүүлээгүй бол эрх бүхий албан тушаалтан тухайн байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг хүчингүй болгуулахаар зөвшөөрөл олгосон байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэж шийдвэрлүүлэх

7.8. Прокурор үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох шийдвэр гаргасны дараа хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд хортой нөлөө үзүүлэх, нийтийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх бараа, эсхүл түргэн муудах буюу гэмтэх, устах, эсхүл чанар нь муудах хөрөнгө, бараа, түүхий эдийг эзэмшигчид нь буцааж өгөх боломжгүй тухай эрх бүхий албан тушаалтны саналыг үндэслэлтэй гэж үзвэл дараахь байгууллагад шилжүүлэх тухай тогтоол гаргана:

7.8.1.хэрэгцээний дагуу зохих байгууллагад;

7.8.2.хадгалуулахаар зохих байгууллагад;

7.8.3.устгуулахаар зохих байгууллагад.

7.9. Хуулийн этгээд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох шийдвэр гаргасны дараа тусгай хадгалалт, хамгаалалт шаардлагатай хөрөнгө, бараа, түүхий эдийг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тухайн байгууллагаас өөр байгууллагад хадгалуулж болно.

7.10. Энэ журамд заасны дагуу үйл ажиллагаа, ашиглалтыг зогсоохдоо хөрөнгө, бараа, түүхий эдийг хадгалах, хамгаалах, хяналт тавих үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтанд тэдгээрийн бүрэн бүтэн байдлыг хариуцуулна.

### **Найм. Хойшлуулшгүй тохиолдолд үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох**

8.1.Прокуророос зөвшөөрөл авч хэрэгжүүлэх хугацаанд зөрчил үргэлжилж хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд хохирол учирч болзошгүй хойшлуулшгүй тохиолдолд эрх бүхий албан тушаалтан үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох акт үйлдэн нэн даруй биелүүлнэ.

8.2. Эрх бүхий албан тушаалтан хуульд заасан тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн бол үйл ажиллагааг нь зогсоож, энэ талаар хэвлэл, мэдээлэлийн хэрэгслийг ашиглан олон нийтэд мэдээлнэ.

8.3. Эрх бүхий албан тушаалтан энэ зүйлийн 8.1, 8.2 дахь хэсэгт заасан арга хэмжээний талаар прокурорт 24 цагийн дотор мэдэгдэнэ.

8.4. Прокурор нь эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаа ашиглалтыг түр зогсоох тухай шийдвэр (акт), холбогдох материалыг хянаж үндэслэлтэй гэж үзвэл тогтоол гаргаж эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.

8.5. Прокурор нь эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох тухай шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл түүнийг хүчингүй болгох тухай прокурорын тогтоол үйлдэж, энэ тухай зөрчлийн холбогдогчид даруй мэдэгдэж, тогтоолын хувийг хүргүүлнэ.

8.6. Прокурор нь эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох тухай хүчингүй болгох шийдвэр гаргасан тухайгаа зөрчлийн холбогдогчид мэдэгдэх хуудсаар болон харилцаа, холбооны хэрэгслийг ашиглан мэдэгдэж болно.

8.7. Прокурор нь эсхүл прокурорын туслах ажилтан зөрчлийн холбогдогчид энэ журмын 3.13-д заасан прокурорын шийдвэрийг харилцаа, холбооны хэрэгслийг ашиглан мэдэгдсэн тохиолдолд энэ талаар тэмдэглэл үйлдэнэ.

### **Ес. Баримт бичгийг хураан авах**

9.1. Эрх бүхий албан тушаалтан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хэвийн явагдах нөхцлийг хангахад зайлшгүй шаардлагатай гэж үзвэл зөрчлийн холбогдогчийн жолоодох эрхийн үнэмлэх, мэргэжлийн үнэмлэх, улсын хил нэвтрэх эрхийн баримт бичиг, үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл зэрэг баримт бичгийг хураан авч тэмдэглэл үйлдэн тэмдэглэлийн хувийг зөрчлийн холбогдогчид хүлээлгэн өгнө.

9.2. Тэмдэглэлд тэмлэглэл үйлдсэн огноо, эрх бүхий албан тушаалтны нэр, албан тушаал, зөрчлийн холбогдогчийн овог, нэр, байгууллага, аж ахуйн нэгжийн нэр, хаяг, зөрчлийн утга, баримт бичгийг хураан авах үндэслэл, хуулийн зүйл заалт, хураан авч буй баримт бичгийн нэр, хавтас, хуудасны тоо зэрэг бусад шаардлагатай зүйлсийг тодорхой тусгана.

9.3. Шаардлагатай тохиолдолд баримт бичгийг хураан авахдаа дуу-дүрсний бичлэг хийх, фото зураг авах зэргээр баримтжуулж болно.

9.4. Баримт бичгийг хураан авсан талаар холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд даруй мэдэгдэж, энэ тухай тэмдэглэл үйлдэж зөрчлийн хэрэгт хавсаргана.

9.5. Зөрчлийг шалгах явцад зөрчлийн холбогдогч хураалгасан баримт бичгийг ашиглах зайлшгүй шаардлагатай бол эрх бүхий албан тушаалтанд хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ.

9.6. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хэвийн явагдах нөхцлийг хангахад саад учруулахааргүй бол хураан авсан баримт бичгийг зөрчлийн холбогдогчид буцаан олгож энэ талаар тэмдэглэл үйлдэнэ.

9.7. Зөрчил шалган шийдвэрлэхэд шаардлагатай бол зөрчлийн холбогдогчид буцаан олгосон баримт бичгийг дахин хураан авч болно.

9.8. Зөрчил шалган шийдвэрлэх явцад баримт бичиг хураан авах үндэслэл арилмагц баримт бичгийг буцаан олгож, энэ талаар тэмдэглэл үйлдэж хэрэгт хавсаргана.

### **Арав. Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх**

10.1. Эрх бүхий албан тушаалтан зөрчлийн холбогдогчийг зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд саад учруулж болзошгүй нөхцөл байдал тогтоогдвол Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх тухай саналыг прокурорт хүргүүлнэ.

10.2. Саналд үйлдсэн огноо, эрх бүхий албан тушаалтны нэр, албан тушаал, зөрчлийн хэргийн дугаар, зөрчлийн холбогдогчийн ургийн овог, эцэг /эх/, өөрийн нэр, регистр, гадаад паспортын дугаар, иргэншил /гадаадын иргэн бол овог, өөрийн нэрийг латин үсгээр бичих/, Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлж буй үндэслэл, хуулийн зүйл, хэсэг зэргийг тодорхой зэргийг дэлгэрэнгүй бичнэ.

10.3. Прокурор нь эрх бүхий албан тушаалтны саналыг үндэслэлтэй гэж үзвэл “Монгол улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх тухай” тогтоол үйлдэн, албан бичгээр эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

10.4. Прокурор нь эрх бүхий албан тушаалтны зөрчлийн холбогдогчийг Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх тухай саналыг үндэслэлгүй гэж үзвэл саналыг хүлээн авахаас татгалзах тогтоол гаргана.

10.5. Эрх бүхий албан тушаалтан прокурорын шийдвэрийг зөрчлийн холбогдогчид танилцуулна.

10.6. Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх тухай прокурорын тогтоолд тогтоол үйлдсэн огноо, прокурорын нэр, албан тушаал, зэрэг дэв, зөрчлийн хэргийн дугаар, зөрчлийн холбогдогчийн ургийн овог, эцэг /эх/, өөрийн нэр, регистр, гадаад паспортын дугаар, иргэншил /гадаадын иргэн бол овог, өөрийн нэрийг латин үсгээр бичих/, Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлж буй үндэслэл, хуулийн зүйл, хэсэг зэргийг тодорхой дурдана.

10.7. Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлсэн этгээд хувийн, эсхүл албан ажлаар гадаад улсад явах зайлшгүй шаардлагаар уг шийдвэрийг түр хугацаагаар цуцлах талаар хүсэлт гаргавал прокурор хянаж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хэвийн явагдах нөхцлийг хангахад саад учруулахааргүй бол цуцлах талаар эрх бүхий байгууллагад албан бичиг хүргүүлнэ.

10.8. Зөрчлийн холбогдогчийн хүсэлтэд гадаад улсад томилолтоор ажиллуулах тухай тушаал, шийдвэр, оролцох хурал, зөвлөлгөөний хөтөлбөр, урилга, виз, гэрээний төсөл, өөрөө болон гэр бүлийн гишүүд нь гадаад улсад эмчилгээ хийлгэх шаардлагатай болсон, гадаад улсад амьдарч буй гэр бүлийн гишүүн, ойрын төрөл садны хүн нь нас барсан, хүндээр өвчилснийг нотолсон эмнэлгийн байгууллагын дүгнэлт, тодорхойлолт зэрэг албан ажил, эсхүл зайлшгүй шаардлагыг нотлох баримтуудыг заавал хавсаргана

10.9. Зөрчил шалган шийдвэрлэх хуульд заасны дагуу Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлсэн шийдвэрийг прокурор цуцалсан бол энэ тухай эрх бүхий байгууллага, зөрчлийн холбогдогчид мэдэгдэнэ.

10.10. Эрх бүхий байгууллага хойшлуулшгүй ажиллагааны явцад Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх үндэслэл бүхий зорчигчийн асуудлыг амралтын болон ажлын бус цагаар нийслэл, дүүрэгт жижүүрийн прокуророос, орон нутагт аймгийн прокурор болон түүний орлогчоос зөвшөөрөл авч, албан бичгийг тусгай шуудан, бие төлөөлөгчөөр Хил хамгаалах ерөнхий газрын шуурхай жижүүрт хүргүүлнэ.

10.11. Энэ журмын 5.12-т заасан ажиллагаа явагдсан тохиолдолд тухайн эрүүгийн хэрэгт хяналт тавьж буй прокурор дараагийн ажлын эхний өдөрт багтаан Хил хамгаалах ерөнхий газарт албан бичиг хүргүүлж, баталгаажуулна.

10.12. Хил хамгаалах байгууллага нь Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх, цуцлах талаар прокурорын байгууллагаас албан бичгээр ирүүлсэн мэдээллийг ажлын цагаар хүлээн авсан бол тухайн өдөртөө, хойшлуулшгүй ажиллагааны явцад ажлын бус цагаар болон амралтын өдөр хүлээн авсан бол 24 цагт багтаан мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

10.13. Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх тухай тогтоол, албан бичгийн хувийг зөрчлийн хэрэгт хавсаргана.

10.14. Прокурор зөрчлийн холбогдогчийн Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлсэн талаар бүртгэл хөтөлнө.

10.15. Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлсэн зорчигчийг хилийн боомтод илрүүлсэн үед хүсэлт гаргасан эрх бүхий байгууллагад хил нэвтрэх эрхийн баримт бичиг, эд зүйлийн хамт акт үйлдэн хүлээлгэн өгнө. Тухайн байгууллагын төлөөлөл байхгүй орон нутагт цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгнө.

10.16. Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлсэн хүсэлт гаргасан байгууллагууд хилийн боомтод саатуулсан зорчигчийг хүлээн авах арга хэмжээг нэн даруй хэрэгжүүлнэ.

10.17. Эрх бүхий байгууллагууд нь Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх, цуцлахтай холбогдсон бүртгэлийг тус бүртээ, Улсын ерөнхий прокурорын газар болон Хил хамгаалах ерөнхий газар нь нэгдсэн бүртгэлийг тус тус хөтөлнө.

10.18. Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх, цуцлах тухай холбогдогчийн нэгдсэн мэдээллийг улирал бүрийн сүүлийн 10 хоногт багтаан Хил хамгаалах ерөнхий газраас Улсын ерөнхий прокурорын газарт хүргүүлж, тодотгоно.

5.19. Хил хамгаалах байгууллага нь Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх, цуцлах тухай прокурорын байгууллагаас ирүүлсэн мэдээллийг ажлын цагаар хүлээн авсан бол тухайн өдөртөө, хойшлуулшгүй ажиллагааны явцад ажлын бус цагаар болон амралтын өдөр хүлээн авсан бол 24 цагт багтаан мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.

10.20. Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх, цуцлах тухай мэдээлийн нэгдсэн санд бүртгэгдсэн иргэн нь зайлшгүй шаардлагатай албаны болон хувийн ажлаар /олон улсын тэмцээн, уралдаанд оролцох, эмчлүүлэх г.м/ гадаадад зорчих зорилгоор эрүүгийн хэрэгт хяналт тавьж буй прокурор тодорхой хугацаагаар зөвшөөрөл олгосон тухай албан бичгийг Хил хамгаалах ерөнхий газарт ирүүлнэ.

10.21. Прокурор Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх, цуцлах тухай хугацааг тодорхой тусгах бөгөөд Монгол Улсын хилээр эргэн орж ирсэн үеэс эхлэн мэдээллийн нэгдсэн сангийн бүртгэлд дахин бүртгэнэ.

10.22. Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх холбогдогчийг хүлээлцсэн тэмдэглэлд саатуулсан огноо, боомтын нэр, зорчигчийн эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, регистр, хил нэвтрэх эрхийн баримт бичгийн дугаар, хил нэвтрэх чиглэл, тээврийн хэрэгсэл /аялал/-ийн дугаар, төрөл, марк, ачаа тээшинд байсан эд зүйл, тэдгээрийн шинж байдал зэргийг тодорхой тусгаж, баримт бичгийн хуулбарын хамт 2 хувь үйлдэнэ. Шаардлагатай бол гэрэл зураг болон дүрс бичлэгээр бэхжүүлж, тэмдэглэлд хавсаргана.

10.23. Эрх бүхий албан тушаалтан Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх, цуцлах тухай шийдвэрийг гарснаас хойш 24 цагийн дотор түүний насанд хүрсэн гэр бүлийн гишүүн, төрөл садангийн хүн болон өмгөөлөгчид нь мэдэгдэх, эсхүл өөрөө мэдэгдэх боломжийг олгоно.

10.24. Эрх бүхий байгууллагууд нь Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх, цуцлах тухай бүртгэлийг Улсын ерөнхий прокурорын газар болон Хил хамгаалах ерөнхий газар нь нэгдсэн бүртгэлийг тус тус хөтөлнө.

10.25. Энэ журамд заасан Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх арга хэмжээ авах үед холбогдогчид түүний эрх, үүргийг танилцуулсан нь эрх бүхий албан тушаалтан мэдүүлэг авах, асуулт тавих, хууль ёсны шаардлага тавих, эрх хэмжээгээ хэрэгжүүлэхэд саад болохгүй.

### **Арван нэг. Барьцаа авах**

11.1. Прокурор нь Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх арга хэмжээг барьцаагаар солиулах тухай зөрчлийн холбогдогчийн гаргасан хүсэлтийг хүлээн авч хангах эсхүл татгалзах шийдвэрийн аль нэгийг гаргана.

11.2. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хэвийн явагдах нөхцлийг хангахад саад учруулахааргүй бол зөрчлийн холбогдогчийн гаргасан хүсэлтийг хангах тухай тогтоол үйлдэнэ. Энэхүү тогтоолд зөрчлийн хэргийн дугаар, зөрчлийн

холбогдогчийн ургийн овог, эцэг /эх/, өөрийн нэр, регистр, гадаад паспортын дугаар, иргэншил /гадаадын иргэн бол овог, өөрийн нэрийг латин үсгээр бичих/, Монгол улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлсэн үндэслэл, хуулийн зүйл, хэсэг, дээрхи эрх хязгаарлах арга хэмжээг барьцаагаар солих болсон үндэслэл, барьцааны хэмжээ, хугацаа зэргийг тодорхой дурдана.

11.3. Уг шийдвэрийг эрх бүхий байгууллагад дээд шатны прокурорын албан бичгээр хүргүүлж, зөрчлийн холбогдогчид мэдэгдэнэ.

11.4. Барьцааны хэмжээг холбогдогчийн хувийн байдал, холбогдсон зөрчил, түүнд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээг харгалзан тогтооно

11.5. Барьцаа нь мөнгөн хэлбэртэй байхаас гадна барьцааны мөнгийг төрийн сан дахь тусгай дансанд хийнэ.

11.6. Эрх бүхий албан тушаалтан барьцааны мөнгийг бэлнээр авахгүй бөгөөд дансанд хийлгэж, холбогдох мөнгөний баримтыг зөрчлийн хэрэгт хавсаргана.

11.7. Эрх бүхий албан тушаалтан зөрчлийн холбогдогчид Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлсэн арга хэмжээг барьцаагаар солиулсаны дараа Зөрчил шалган шийдвэрлэх хуулийн 5.5 дугаар зүйлийн 9,11 дүгээр зүйлд заасан үр дагавар үүсэхийг тайлбарлан өгч, энэ талаар тэмдэглэл үйлдэн хэрэгт хавсаргана.

11.8. Зөрчил шалган шийдвэрлэх хуулийн 5.5 дугаар зүйлийн 7-д заасан хуулийн этгээдээс барьцаа авахыг хориглоно.

11.9. Барьцааны мөнгийг хадгалах, буцаан олгоход Улсын Ерөнхий Прокурор, Санхүү төсвийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний баталсан журмыг баримтална.

11.10. Зөрчлийн холбогдогч саатуулах эрх хязгаарлах арга хэмжээг барьцаагаар солиулах хүсэлт гаргасан нь шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байх үндэслэл болохгүй.